



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 12 сарын 11 өдөр

Дугаар 0/137

Улаанбаатар хот

Сүхбаатар дүүргийн 143 дугаар  
цэцэрлэгийн данс бүртгэлд  
хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу хавсралтад заасан нийт 6,820,000.0 /зургаан сая найман зуун хорин мянга/ төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэн авахыг Сүхбаатар дүүргийн 143 дугаар цэцэрлэг /Б.Анхмаа/-т зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Сүхбаатар дүүргийн 143 дугаар цэцэрлэг /Б.Анхмаа/-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ



Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын  
 газрын даргын 2019 оны 111 дугаар  
 сарын 11 өдрийн А/ тоот тушаалын хавсралт

Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Сүхбаатар дүүргийн 143 дугаар цэцэрлэг

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Үзүүлэлт	Ашиглалтад авсан он	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэх		Хандивлагч байгууллага	
								Нэгжийн үнэ	Нийт үнэ	нэр	Эх үүсвэр
1	Аяга таваг ариутгагч	Yinli	2 тасалгаатай ариутгагч	2019	сайн	ш	13	350,000.0	4,550,000.0	Эцэг эхчүүд	хандив
2	Зурагт	LG	42 inch	2019	сайн	ш	1	290,000.0	290,000.0		
3	Проектор, дэлгэц	Epson	43 inch	2019	сайн	ш	1	1,400,000.0	1,400,000.0		
4	Агаар цэвэршүүлэгч	mi air		2019	сайн	ш	1	580,000.0	580,000.0		
Тоног төхөөрөмжийн дүн									6,820,000.0		